



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2017 оны 03 сарын 18 өдөр

Дугаар 34

Номгон

**Жендэрийн эрх тэгш байдлын аймгийн
салбар хорооны ажиллах журам батлах тухай**

Монгол Улсын Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Жендэрийн эрх тэгш байдлын аймгийн салбар хорооны ажиллах журмыг хавсралтаар баталсугай.


2. Журмыг үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Засаг дарга, Жендэрийн эрх тэгш байдлын аймгийн салбар хорооны дарга /Г.Батжаргал/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д даалгасугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР



ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫН АЙМГИЙН САЛБАР ХОРООНЫ ЖУРАМ

Салбар хорооны зорилго: Улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёл, гэр бүлийн харилцаанд жендэрийн эрх тэгш байдлыг хангах нөхцөл бүрдүүлэх, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хуулийн хэрэгжилтийг хангахад төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн зүгээс гаргасан үүсгэл санаачлагыг дэмжих, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Жендэрийн эрх тэгш байдлын аймгийн салбар хороо /цаашид салбар хороо гэх/ нь жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлэхэд төр, нийгмийн тэнцүү оролцоог хангаж, тогтвортой ажиллах баталгааг бүрдүүлсэн орон тооны бус хороо мөн

1.2 Салбар хороо нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомж, дүрэм, журмыг удирдлага болгоно

Хоёр. Салбар хорооны бүтэц, бүрэлдэхүүн, зохион байгуулалт

1.1 Салбар хорооны бүрэлдэхүүн, ажиллах журмыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид батална.

1.2 Салбар хорооны дарга нь аймгийн Засаг дарга, орлогч дарга нь аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, нарийн бичгийн дарга нь аймгийн Засаг даргын Тамгын газрын Жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн байна.

1.3 Салбар хорооны бүрэлдэхүүн нь төрийн байгууллага, иргэдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдэнэ.

1.4 Салбар хороо нь хагас, бүтэн жилээр хуралдана. Шаардлагатай үед салбар хорооны дарга ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж болно.

1.5 Нийт гишүүдийн 50 ба түүнээс дээш хувийн ирцтэйгээр салбар хорооны хурлыг хуралдуулна. Хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг урьдчилан гаргаж, гишүүдэд 3 хоногын өмнө хүргэсэн байна.

1.6 Салбар хороо нь бүтэн жилээр ажлаа төлөвлөж Жендэрийн эрх тэгш байдлын тухай хууль, Аймгийн Жендэрийн тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулан ажиллана.

1.7 Зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудлыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. Санал тэнцсэн тохиолдолд асуудлыг хуралдаан даргалагчийн саналаар шийдвэрлэнэ

1.8 Салбар хороо нь тухайн жилийн тайлангаа аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд дараа оны 01 дүгээр сарын 10-ны дотор тайлагнана

1.9 Аймгийн Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилт, хүйсийн тэнцвэрт байдлын судалгааны тайланг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Жендэрийн ажлын албанд хуулинд заасан хугацаанд /Дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор/ хүргүүлнэ.

1.10 Сумын түвшинд Засаг дарга салбар хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулж Нийгмийн түншлэлийн багийн үйл ажиллагаатай уялдуулан ажиллаж, тайланг жендэрийн салбар хороонд жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор ирүүлэх

Гурав.Салбар хорооны эрх, үүрэг

3.1 Салбар хороо нь дараах эрхтэй байна.

3.1.1 Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, үндэсний хөтөлбөр, аймгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, зөвлөмж чиглэл өгөх

3.1.2 Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр зарцуулж байгаа хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих

3.1.3 Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 5 дугаар бүлгийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх заалтыг үндэслэн хууль тогтоомж зөрчсөн этгээдийг шүүхээр захиргааны шийтгэл ногдуулахаар шилжүүлнэ

3.2 Салбар хороо нь дараах үүрэгтэй байна

3.2.1 Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон Үндэсний хорооноос гаргасан зөвлөмж, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг орон нутагтаа зохион байгуулж, биелэлтэд хяналт тавих

3.2.2 Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх

3.2.3 Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагаанд олон нийтийн хүчийг дайчлан салбар хоорондын зохицуулалт, зохион байгуулалтын арга хэмжээг авч, эрх бүхий албан тушаалтанд үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой санал, санхүүжилтийн асуудлыг тавьж шийдвэрлүүлэх, олон нийтийн санал санаачлагыг дэмжих, төрийн болон олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах

3.2.3 Жендэрийн эрх тэгш байдлыг хангах асуудлын аймгийн хэмжээний хүрээг тодорхойлж, жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгах

3.2.4 Жендэрийн эрх тэгш байдлыг хангах төрийн бодлого, хууль тогтоомжийг аж ахуйн нэгж, байгууллага олон нийтэд таниулах, сурталчлах үйл ажиллагааг орон нутгийн

хэвлэл мэдээлэл, олон нийтийн болон хувийн хэвшлийн байгууллагатай хамтран зохион байгуулах, жендэрийн эрх тэгш байдлыг хангах ажлын үр дүнгийн тухай мэдээлэх

3.2.5 Гэр бүлийн тухай болон Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд удирдан зохион байгуулж, хяналт тавих

3.2.6 Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр ажлын төлөвлөгөө хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг жил бүр төлөвлөн, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулах

_____оОо_____